



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй, нийт 141,088,346.10 (нэг зуун дөчин нэгэн сая наян найман мянга гурван зуун дөчин зургаан төгрөг арван мөнгө) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг тус газрын харьяа "Сүлд" биеийн тамир, спортын хороонд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй, 13,064,000.00 (арван гурван сая жаран дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Загджав, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001581

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
090 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"СҮЛД" БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, байршил	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Дулаан дамжуулах далд шугам (2 ф76, ф25, ф20, ф25 мм-голчтой дулааны шугам, Хан-Уул дүүргийн 11-р хороо)	2020	м	211.8	141,088,346.10
	Нийт дүн				141,088,346.10 (нэг зуун дөчин нэгэн сая наян найман мянга гурван зуун дөчин зургаан төгрөг арван мөнгө)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
09.0 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"УБЦТС" ТӨХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл, байршил	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Цахилгаан дамжуулах агаарын шугам (306 кВА, Хан-Уул дүүргийн 11-р хороо)	2021	м	368	13,064,000.00
	Нийт дүн				13,064,000.00 (арван гурван сая жаран дөрвөн мянган)